



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭГЧДИЙН ШУДАРГА ӨРСӨЛДӨХ
НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ
НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ,
ДҮГНЭЛТ

2026



ОРШИЛ	4
I. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	6
Нэг. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр	6
Хоёр. Зохицуулах хорооноос хийж буй хяналт, мониторингийн талаар.....	6
Гурав. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтэд хийсэн үнэлэлт, дүгнэлт.....	7
Дөрөв. Зохицуулах хорооноос хийж гүйцэтгэсэн хяналтын талаар	8
Тав. Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил	9
II. ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН, СУНГАСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН, СЭРГЭЭСЭН, ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТОО, МЭДЭЭ...	11
Нэг. Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо тогтоосон байдал, сонгон шалгаруулалтын дүн.....	11
Хоёр. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байдал	12
Гурав: Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал	13
Дөрөв. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байдал.....	14
III. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙЛГАХ ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ	15
IV. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ, ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ	16
Нэг. Монгол Улсын хүн ам, өрхийн тоо, нягтралын байдал	16
Хоёр. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо	16
Гурав. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдал.....	17
V. ХОРООНООС 2026 ОНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОО ТОГТООХ ЭСЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ХАРГАЛЗАН ҮЗСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ШИЙДВЭР	31
Нэг. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлтүүд	31
Хоёр: Тус Хорооноос 2026 онд сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх тухай	33

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Радио, телевизийн хяналт мониторингийн дүнгээр арга хэмжээ авсан байдал	8
хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгосон байдал	11
хүснэгт 3. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байдал	12
хүснэгт 4. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал	13
хүснэгт 5. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байдал	14
хүснэгт 6. Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээгээр .	16
хүснэгт 7. Телевизийн зах зээлийн хэмжээ	17
хүснэгт 8. Телевизийн зах зээлийн хэмжээ - төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ тус бүрээр	18
хүснэгт 9. Өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн хэмжээ.....	18
хүснэгт 10. Өргөн нэвтрүүлгийн телевизийн орлогын задаргаа.....	19
хүснэгт 11. Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн орлого, зардлын хэмжээ	21
хүснэгт 12. Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний түвшин.....	22
хүснэгт 13. Арилжааны телевизийн орлогын задаргаа	24
хүснэгт 14. Улаанбаатар хотын арилжааны телевизийн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний түвшин	25
хүснэгт 15. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тооны өөрчлөлт (идэвхтэй хэрэглэгчийн тоогоор).....	26
хүснэгт 16. Улаанбаатар хотын олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний түвшин.....	28
хүснэгт 17. Улаанбаатар хотын радиогийн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний түвшин	29
хүснэгт 18. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн тоо тогтоосон, олгосон байдал	30

Зургийн жагсаалт

Зураг 1. Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр.....	27
зураг 2. Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр, хувиар.....	27

ОРШИЛ

Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь хэсэгт заасан эрх, үүргийн дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, жил бүр үнэлэлт, дүгнэлт гаргаж ажиллах бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХХЗХ нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хүрээнд олгогдсон бүрэн эрх, чиг үүрэг, өргөн нэвтрүүлгийн салбарт төрөөс баримтлах бодлого, бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд зохицуулалт хийж, зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг хангуулж ажилладаг.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчилсан. Иймээс өргөн нэвтрүүлгийн бодлого, зохицуулалтын болон салбарын үйл ажиллагаанд зайлшгүй баримтлах зарчмуудыг тус хуулийн 5 дугаар зүйлээр заасан ба 5.1.9-д "... зах зээлийн өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлж, өргөн нэвтрүүлгийн салбарын хөгжлийг дэмжин хөгжүүлэх" зарчмыг баримтлахаар хуульчилсан байдаг.

ХХЗХ нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10-т заасныг үндэслэн хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж, дүрэм журам, нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангуулах замаар өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээтэй холбоотой онцлог зохицуулалтыг хэрэгжүүлж, өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах, шударга өрсөлдөх нөхцөлийг бий болгох, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5-д зааснаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн талаарх мэдээллийг жил бүр олон нийтэд ил тод мэдээлж байна. ХХЗХ нь хуульд заасан дээр чиг үүрэг, зорилгын хүрээнд бүрэн эрхийнхээ дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотой үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг тогтмол авч ажиллаж байгаа бөгөөд зах зээл, хүн ам, эрэлт хэрэгцээ, эзэмшил, нөхцөл байдлын судалгаанд үндэслэн өрсөлдөөний нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, тусгай зөвшөөрлийн тоо тогтоох, олгох эсэх шийдвэрийг судалгаа, үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн 2021 оноос жил бүр гаргаж байна.

ХХЗХ-оос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт гаргахад дараах үндсэн чиглэлийг авч үздэг бөгөөд үүний хүрээнд хийсэн судалгаа, мэдээлэлд үндэслэн үнэлэлт, дүгнэлт гаргадаг болно. Үүнд:

- I. Өргөн нэвтрүүлгийн хууль эрх зүйн орчин, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хийсэн үнэлэлт, дүгнэлт, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
- II. Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тоо, мэдээ;
- III. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эзэмшлийн талаарх мэдээллийг ил тод байлгах зохицуулалт, хэрэгжилтийн нөхцөл байдал, үнэлэлт, дүгнэлт;
- IV. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээл, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаа, үнэлэлт, дүгнэлт;
- V. ХХЗХ-оос 2026 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлт, шийдвэр.

Дээрх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, мэдээлэл, судалгаа, үнэлгээ дүгнэлтийг дэлгэрэнгүй авч үзье.

I. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Нэг. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр

Өргөн нэвтрүүлгийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр Хорооны 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д 250 дугаар тогтоолоор, “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д 251 дүгээр тогтоолоор, “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д 252 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг хийлгэсэн. Нөхцөл, шаардлагуудад нэмэлт, өөрчлөлтийг дараах үндэслэлээр хийсэн. Үүнд:

- I. Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын хүрээнд байгуулагдсан Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор батлан гаргасан 01 тоот дүгнэлтээр зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасахыг даалгажээ. Үүнтэй уялдуулан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг агуулсан захиргааны хэм хэмжээний актуудыг хянаж, холбогдох заалтыг хүчингүй болгох арга хэмжээг авах,
- II. Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно.” гэсний дагуу тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх нөхцөл буюу шаардагдах баримт бичгийг заасан заалтуудыг хүчингүй болгохоор,
- III. Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 “захиргааны хэм хэмжээний акт дараах шаардлагыг хангасан байна гэсэн хэсгийн 60.1.8. бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх” гэсний хүрээнд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн заалттай давхцсан заалтуудыг хасах,
- IV. Үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор онцын шаардлагагүй материал, мэдээ тайлан авахгүй байх, зарим шаардлагагүй зохицуулалтыг хүчингүй болгох гэсэн зорилгуудын хүрээнд нөхцөл, шаардлагуудад нэмэлт, өөрчлөлтүүдийн оруулсан.

Хоёр. Зохицуулах хорооноос хийж буй хяналт, мониторингийн талаар

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс үйлчилгээний тасралтгүй ажиллагааны тайланг (ТАТ) тогтмол хүлээн авч, үйлчилгээний хэвийн тасралтгүй ажиллагааг хангуулах чиглэлээр телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн эфирийн ТАТ тайланг тус хорооноос хийдэг байнгын хяналт, мониторингийн хүрээнд болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид,

телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс гэсэн 3 талаас хүлээн авч нэгтгэн, анализ хийж байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. ([Тасралтгүй ажиллагааны тайлан](#)) Үйлчилгээ нь тасарсан үйлчилгээ эрхлэгчдээс эфир тасарсан шалтгааныг тодруулж, хариу тайлбар аван, анхааруулга хүргүүлэн ажиллаж байна.

ХХЗХ нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.8-д заасан эрх, чиг үүргийн хүрээнд “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”, “Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Радиоогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын хэрэгжилтэд байнгын хяналт, мониторинг хийж байна.

2025 онд телевизийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн хүрээнд:

- Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүдээс Монголын үндэсний олон нийтийн 1 суваг, өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, арилжааны 37-42 телевиз мониторингид хамрагдсан.
- Орон нутагт тусгай зөвшөөрөлтэй нийт 45 телевизүүдээс түүврийн аргаар буюу сард 15 телевизийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийж байна.

Радиоогийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн хүрээнд:

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй радиоогийн (Монголын үндэсний олон нийтийн 4 радио, арилжааны 31 радио) хөтөлбөрт түүврийн аргаар буюу сар бүр 4 радиоогийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийж байна.

ХХЗХ нь радио, телевизийн хөтөлбөрт хийсэн хяналт, мониторингийн тайланг үйлчилгээ эрхлэгчдэд тогтмол хүргүүлэх, холбогдох арга хэмжээ авах, хяналт, мониторингийн тайлан, мэдээг олон нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна. Телевизийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн тайлан, мэдээллийн дэлгэрэнгүйг <https://www.crc.gov.mn/monitoringiin-tailan-televiz> хуудсаас, радиоогийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүн, мэдээллийн дэлгэрэнгүйг <https://www.crc.gov.mn/monitoringiin-tailan-2> хуудсаас сар, улирлаар дэлгэрэнгүй үзэх боломжтой.

Түүнчлэн радио, телевизийн 2025 оны хөтөлбөрийн мониторингийн бүтэн жилийн тайлан, мэдээг аналитик дүгнэлттэйгээр энэ жил анх удаа цахим товхимол байдлаар бэлтгэн Хорооны цахим хуудсанд нээлттэй байршуулсныг <https://www.crc.gov.mn/monitoringiin-ziliin-tailan> хуудсаас дэлгэрэнгүй үзэх боломжтой.

Гурав. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтэд хийсэн үнэлэлт, дүгнэлт

ХХЗХ нь радио, телевизийн хөтөлбөрийн хяналт мониторингийн тайланг сар, улирал, хагас, бүтэн жилээр гарган дүнг тухай бүр үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлэх, байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд ил тод мэдээлэх, зөрчилтэй үйлчилгээ эрхлэгчдэд зөрчлийг арилгуулах чиглэлээр холбогдох арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Түүнчлэн радио, телевизийн хөтөлбөр, зар сурталчилгааны журмын хэрэгжилтийн тайланг хагас жил, бүтэн

жилээр өмнөх онуудтай харьцуулан Даргын зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр, 08 дугаар сарын 25-ны өдөр, 2026 оны 03 дугаар сарын 05, 19-ний өдрүүд ийн болон Хорооны 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр, 08 дугаар сарын 28-ны өдөр, 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаануудад тус тус танилцуулсан.

2025 онд мониторингийн дүнгээр нийт 120 албан бичгийг үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлэв. Эдгээр нь:

Хүснэгт 1. Радио, телевизийн хяналт мониторингийн дүнгээр арга хэмжээ авсан байдал

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл	Зөвлөмж хүргүүлэх тухай	Анхааруулга хүргүүлэх тухай	Хугацаатай үүрэг даалгавар	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх сонсох ажиллагаа явуулсан	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох сонсох ажиллагаа явуулсан
Өргөн нэвтрүүлгийн телевиз	6	2	4	1	-
Арилжааны телевиз	11	20	15	2	-
Орон нутгийн телевиз	13	7	8	3	5
Радио	12	9	2	-	-
Нийт	42	38	29	6	5

2025 онд хяналт, мониторингийн дүнгээр 8 үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээс (Улаанбаатар хотын арилжааны 3 телевиз, орон нутгийн 5 телевиз), 7 үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг холбогдох хуулийн дагуу (Улаанбаатар хотын арилжааны 2 телевиз, орон нутгийн 5 телевиз) хүчингүй болгосон¹.

Дөрөв. Зохицуулах хорооноос хийж гүйцэтгэсэн хяналтын талаар

Зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, нөхцөл шаардлага, гэрээний үүргийн хэрэгжилтийн байдалд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт

¹Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тоо, мэдээнээс дэлгэрэнгүй үзнэ үү.

бус хяналтыг хийж хуульд заасан холбогдох арга хэмжээг авч, зөвлөгөө мэдээлэл өгч ажилладаг.

Хорооны даргын 2025 оны А/56 тоот тушаалын дагуу Улаанбаатар хотын 34 телевиз, 2 радиогийн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх төлөвлөгөөт үзлэг, хяналтыг хийсэн. Хяналтын дүнгээр үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийн тоо, хэмжээнээс хамааруулан 9 үйлчилгээ эрхлэгчид зөвлөмж, 22 үйлчилгээ эрхлэгчид хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулсан бол 3 үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, үүнээс 2 үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийх хяналт хийх ажлын хүрээнд Хорооны даргын 2025 оны А/136 дугаар тушаалын дагуу Завхан, Увс, Ховд, Говь-Алтай, Баян-Өлгий аймгийн нийт 20 үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтэд 06 дугаар сарын 02-оос 10-ны өдрүүдэд төлөвлөгөөт үзлэг, хяналт хийсэн. Эдгээрээс 9 үйлчилгээ эрхлэгчид зөвлөмж өгсөн бол 2-т нь хугацаатай үүрэг даалгавар өгч, 1 үйлчилгээ эрхлэгчид тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай мэдэгдэл өгсөн бол 8 үйлчилгээ эрхлэгчид хяналтын ажлын дүнг хүргүүлж ажиллаа.

Хорооны даргын 2026 оны А/44 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн хүрээнд Улаанбаатар хотод олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх -11, радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх -1 тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн гэрээний үүргийн биелэлтэд 2026 оны 02 дугаар сарын 26-наас 03 дугаар сарын 20-ны өдрийн хооронд хяналтыг зохион байгуулсан. Хяналтын явцад “Оптимум” ХХК нь үйл ажиллагаагаа түр зогсоосон байсан тул тус байгууллагад хийх хяналтыг 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр дахин зохион байгуулахаар хойшлуулсан. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч 9 байгууллагад “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 7.2-т заасны дагуу мэдэгдэл хүргүүлэх, 1 үйлчилгээ эрхлэгчид хяналтын дүнг хүргүүлсэн. Мөн радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Радио, телевизийн газрын сүлжээ УТҮГ-тай 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр уулзаж, хяналтын дүнг танилцуулан, цаашид авах арга хэмжээний талаар тодруулга авч ажилласан.

Тав. Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар радио, телевизээр хүүхэд залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх агуулга тухайлбал хуулиар хориглосон хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан, хар тамхи, сэтгэхүйд нөлөөлөх эм бэлдмэл бэлтгэн боловсруулах, хэрэглэх зэрэг бүтээлийг нэвтрүүлэхийг хориглож нэвтрүүлэгт насны ангиллын тэмдэглэгээ ашиглах, цагийн хязгаарлалтыг баримтлах зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Энэхүү зохицуулалтын хүрээнд Зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30.1.7а-д заасан чиг үүргийн дагуу радио, телевизийн хөтөлбөрт хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн агуулгын хэм хэмжээг хуулиар хязгаарласан буюу хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д заасан агуулгын хүрээнд тодорхойлж, “Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах

радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм"-ийг батлан гаргаж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих Орон тооны бус зөвлөл нь зохисгүй агуулгатай холбоотой дараах төрлийн асуудлуудыг хуралдаанаараа хэлэлцэн, дүгнэлт гарган шийдвэрлэж байна. Үүнд:

- Радио, телевизээр зохисгүй агуулгатай контент, нэвтрүүлэг нэвтрүүлсэнтэй холбоотой иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, тухайн агуулга нь зохисгүй эсэхэд дүгнэлт гаргаж, шийдвэрлэх;
- Өдрийн цагаар 18+ тэмдэглэгээтэй контент нэвтрүүлсэн зөрчлүүд;
- Насны ангиллын тэмдэг тэмдэглэгээ буруу тавьсан болон тавиагүй зөрчлүүд;
- Телевизийн хөтөлбөрийн хяналт мониторингийн дүнгээр өдрийн цагаар хөтөлбөрийн дүрэм зөрчсөн байж болзошгүй, илт зохисгүй гэж үзэх агуулга бүхий киног нэвтрүүлсэн тохиолдлуудын талаарх хяналт, мониторингийн дүнтэй танилцаж, зөрчлүүдтэй холбоотойгоор хэлэлцэж, холбогдох зөвлөмж, мэдэгдлийг телевизүүдэд хүргүүлж, дүрмийн хэрэгжилтийг хангахад анхааран ажиллаж байна.

Иргэдээс радио, телевизээр хүүхдэд зохисгүй агуулга, хараалын үг хэллэг бүхий контент нэвтрүүлж байгаа тухай гомдол 2025 онд 3, 2026 оны 1 дүгээр улиралд мөн 3 гомдол ирсэн бол 2026 оны 1 дүгээр улиралд ДДЭШ ТВ ХХК-ийн олон суваг дамжуулах үйлчилгээний кино санд байршсан насанд хүрэгчдэд зориулсан кинонуудын трейлер нь ямар нэг техникийн хязгаарлалтгүйгээр нээлттэй байршиж байгаа нь хүүхэд, залууст зохисгүй байна гэсэн агуулга бүхий гомдол ирсэн.

Гомдол ирсэн талаар холбогдох үйлчилгээ эрхлэгчдэд мэдэгдэж, хариу тайлбарыг авч Орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гомдлын агуулгатай холбоотойгоор өөрийн редакцад хяналт тавьж ажиллах, зөрчил бүхий контентыг дахин нэвтрүүлэхгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар заавар, зөвлөмжийг 2 үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн. ДДЭШ ХХК-ийн кино санд байршуулсан киноны трейлэртэй холбоотой гаргасан гомдлын дагуу хянаж үзэхэд насанд хүрэгчдэд зориулсан киноны трейлерийг ямар нэгэн техникийн хязгаарлалтгүйгээр нээлттэй байршуулсан нь тогтоогдсон. Уг үйлдэл нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7, 25.8, 25.9, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын 6.2.8, 6.11 дэх заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж, зөрчлийг нэн даруй таслан зогсоох, хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах зорилгоор хаах, түгжих, эцэг эхийн хяналтын тохиргоог хэрэгжүүлэх, цаашид холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж ажиллах талаар арга хэмжээ авах тухай албан тоот хүргүүлсэн.

Түүнчлэн Орон тооны бус зөвлөлд танилцуулж, хэлэлцүүлсний дүнд гарсан дүгнэлт, шийдвэрийг иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд болон гомдол гаргасан тухайн иргэнд хариу тайлбар, мэдээлэл хэлбэрээр өгч ажиллаа. Мөн Орон тооны бус зөвлөлийн хуралдааны талаарх улирал тутмын тайлан мэдээнд ирүүлсэн гомдол, хуралдаанаас гарсан дүгнэлт, гомдол шийдвэрлэлтийн явц, үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг тогтмол тусган тайлагнаж байна.

Телевизийн хөтөлбөрийн мониторингийн 2025 оны тайлангийн дүнгээр насанд хүрэгчдэд зориулсан контентыг 06-22 цагийн хооронд нэвтрүүлсэн, цагийн хязгаарлалт зөрчсөн гэх зэрэг зөрчлийн тайланг нэгтгэн гаргаж Орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүсэн. Үүний үр дүнд нийт 22 телевизийн холбогдох зөрчлийг хэлэлцэж мэдэгдэл анхааруулга, зөвлөмж хүргүүлж ажиллалаа. Үүнд:

- 06:00-22:00 цагийн хооронд 18+ цагийн кино, контент нэвтрүүлэхгүй байх шаардлага зөрчсөн, насны ангиллын тэмдэг, тэмдэглэгээг тавиагүй эсхүл буруу тавьсан талаар мэдэгдлийг Мянгат малчин, NTN, Channel 11, 25-р суваг, Хөгжил, BBS, Буян, М кино гэсэн 8 телевизэд мөн 3 телевизэд зөвлөмж өгсөн.
- Хүүхдэд зохисгүй агуулга нэвтрүүлсэн Лайк, D1, Өндөрхаан, Сүлд, ТВ5, Аист Глобал, X TV, DBS, Дорнын ТВ6 гэсэн 9 телевизэд мэдэгдэл өгсөн.

II. ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН, СУНГАСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН, СЭРГЭЭСЭН, ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТОО, МЭДЭЭ

ХХЗХ-ноос 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 2026 оны 05 дугаар сарын 01-ний хооронд холбогдох хууль, тогтоомжийн дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, дуусгавар болох үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлж ажилласан.

Нэг. Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо тогтоосон байдал, сонгон шалгаруулалтын дүн

ХХЗХ-ны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 дугаар тогтоолоор 2025 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоог баталсан. Уг тогтоолоор радиогийн үйлчилгээ эрхлэх 4 (Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дундговь аймгуудад), өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх 1 (Увс аймагт), орон нутагт арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх 2 (Говьсүмбэр, Дундговь аймгуудад үйлчилгээ эрхлэх), Монгол улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх 2, Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэх хүрээтэй арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх 3 тусгай зөвшөөрлийн тоог тус тус тогтоож, нээлттэй сонгон шалгаруулалт зарлахаар болсон.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгосон байдал

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ	Сонгон шалгаруулалтаар олгохоор зарласан тусгай зөвшөөрлийн тоо	Үүнээс	
		Олгосон	Татгалзсан
Арилжааны радио - Орон нутагт	4 (4 аймагт)	-	-

Өргөн нэвтрүүлгийн телевиз - Орон нутагт	1 (1 аймагт)	1 ²	-
Арилжааны телевиз - Орон нутагт	2 (2 аймагт)	-	-
Арилжааны телевиз - Монгол улс	3	3 ³	-
Арилжааны телевиз - Улаанбаатар хот	2	2 ⁴	-
Нийт	12	6	-

Нээлттэй сонгон шалгаруулалтыг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 10.9, 10.10 дахь заалтуудын дагуу зохион байгуулан, шаардлага хангасан хүсэлт гаргагчдад тусгай зөвшөөрөл олгон, тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулсан. Үйлчилгээний 3 төрөлд нийт 12 үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоор сонгон шалгаруулалт явуулснаас 6 телевизийн тусгай зөвшөөрөл олгогдсон орон нутагт үйлчилгээ эрхлэх 6 тусгай зөвшөөрөлд хүсэлт ирээгүй болно.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байдал

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийн хугацааг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдлыг Хүснэгт 3-т үзүүлээ.

Хүснэгт 3. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байдал

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл	Сунгалт хийх хүсэлт ирүүлсэн тусгай зөвшөөрлийн тоо	Үүнээс	
		Сунгасан	Татгалзсан
Өргөн нэвтрүүлгийн телевиз	1	1 ⁵	-
Арилжааны телевиз	1	1 ⁶	-
Арилжааны радио	4	4 ⁷	-
Олон суваг дамжуулах үйлчилгээ	5	5 ⁸	-
Нийт	11	11	-

² МВС ТВ ХХК-ийн МВС телевиз

³ Монгол контент ХХК-ийн GoGoTV, Плэймакс анимүүд ХХК-ийн PlayMax, Хөтөч чиглэл суваг ХХК-ийн Шүүхийн суваг телевиз

⁴ Эн Ти Ви Бродкастинг ХХК-ийн N Movies, Ууган суваг ХХК-ийн UTV телевиз

⁵ Очир Арвай ХХК-ийн Төв телевиз

⁶ Медиа холдинг ХХК-ийн ТВ9-2

⁷ Тэргүүн медиа ХХК-ийн Стар ФМ 92.5, Сета тек ХХК-ийн Аялгуу ФМ 89.3, Эм Жи Эл Радио ньус ХХК-ийн MGLRadio ФМ 88.3, МОНБЗ продакшн ХХК-ийн Монгол тандаа зүтгэе залуусын радио 98.9.

⁸ Би Ти Жи ХХК-ийн БиТиЖи КаТВ, Дөрвөн шарга ХХК-ийн Дөрвөн Шарга КаТВ, Хаан Алтай Ховд ХХК-ийн Хаан Алтай Ховд КаТВ, ЖСММ БГБХ нөхөрлөл-ийн ЖСММ КаТВ, Цацраг трейд ХХК-ийн Цацраг трейд КаТВ.

2025 он болон 2026 оны эхний 5 сарын байдлаар өргөн нэвтрүүлгийн 11 үйлчилгээ эрхлэгч тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлтээ хуулийн хугацаанд ирүүлснийг бүгдийг хянаж шийдвэрлэсэн.

Гурав. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан үндэслэн 2025 он болон 2026 оны эхний 5 сарын байдлаар 3 телевизийн тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу шилжүүлж, нэг телевизийн нэрийг өөрчилж, нэг олон суваг дамжуулах үйлчилгээний үйлчилгээ эрхлэх хүрээнд нэмэлт оруулсан.

Хүснэгт 4. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал

Тусгай зөвшөөрлийн төрөл	Өөрчлөлт оруулсан тусгай зөвшөөрлийн тоо	Үүнээс		
		Тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн, хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн	Үйлчилгээ эрхлэх хүрээ өөрчилсөн	Үйлчилгээний нэр өөрчилсөн
Арилжааны телевиз	2	1 ⁹	-	1 ¹⁰
Төлбөртэй телевиз	1	1 ¹¹	-	-
Арилжааны радио	1	1	-	-
Олон суваг дамжуулах үйлчилгээ	1	-	1	-
Нийт	5	3	1	1

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан үндэслэн 2025 он болон 2026 оны эхний 5 сарын байдлаар 3 телевизийн тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу шилжүүлж, нэг телевизийн нэрийг өөрчилж, нэг олон суваг дамжуулах үйлчилгээний үйлчилгээ эрхлэх хүрээнд нэмэлт оруулсан.

Мөн Салхи энтертайнмент ХХК-ийн хүсэлтээр Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн үйлчилгээ эрхлэх хүрээг бууруулан өөрчлөлт оруулж Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэх болгосон. Үүнтэй холбоотойгоор Салхи энтертайнмент ХХК-ийн орон нутагт радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

⁹ Монголиан ньюс чаннел ХХК-ийн МНС телевизийн тусгай зөвшөөрлийг Лэйди Чаннел ХХК-д шилжүүлсэн.

¹⁰ Трионикс мета вишн ХХК-ийн Попкорн телевизийн нэрээ Bantap болгон өөрчилсөн.

¹¹ Юпланет ХХК-ийн Юнилайв телевизийн тусгай зөвшөөрлийг Контент дистрибушн ХХК руу шилжүүлсэн.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байдал

Энэхүү үнэлгээ, дүгнэлтийн хамрах хугацаанд буюу 2025 он, 2026 оны эхний 5 сарын байдлаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх 21 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Хүснэгт 5. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байдал

Тусгай зөвшөөрлийн төрөл	Хүчингүй болсон тусгай зөвшөөрлийн тоо	Үндэслэл
Өргөн нэвтрүүлгийн телевиз	9	Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.1 – тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан - 4 ¹² Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.2 - зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй - 3 ¹³ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17.1.1 тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан - 2 ¹⁴
Арилжааны телевиз	3	Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.1 – тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан - 1 ¹⁵ Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.2 - зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй - 1 ¹⁶ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17.1.1 тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан - 1 ¹⁷
Төлбөртэй телевиз	2	Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.1 – тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан - 2 ¹⁸
Арилжааны радио	3	Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.1 – тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан – 3 ¹⁹ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17.1.1 тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан - 1 ²⁰

¹² Бунадо ХХК-ийн Тэнгэр, Ишилан ХХК-ийн EBS, Ёл цуурай ХХК-ийн UCTV, Төв Ньюс ХХК-ийн Төв телевизүүд

¹³ Ойрад тв ХХК-ийн Ойрад ТВ, Миний Монгол энтертэймент ХХК-ийн Миний Монгол, Говийн долгион мэдээллийн төв ТББ-ийн Говийн наран телевизүүд

¹⁴ Хоса тв ХХК-ийн МВС, Ногоон замын эхлэл ХХК-ийн Алтай телевизүүд

¹⁵ Эгон ХХК-ийн Шоп Монголиа телевиз

¹⁶ Төгс барчин хангай ХХК-ийн Цахим Монгол телевиз

¹⁷ Эс Си Эйч ХХК-ийн Суваг 1 телевиз

¹⁸ Монвсат нэтворк ХХК-ийн 998, 994 телевизүүд

¹⁹ Хасүби медиа ХХК-ийн ФМ 89.5, Багануур хөгжлийн зам ТББ-ын ФМ 104.5 радионууд

²⁰ Стандарт Ви Оү Эй ХХК-ийн ФМ 106.6 радио

Олон суваг дамжуулах үйлчилгээ	3	Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.1 – тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан – 2 ²¹ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17.1.1 тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан - 1 ²²
Нийт	20	

Үүнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн хүсэлтээр 11 зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.1-д заасан үндэслэлээр, зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлт ирүүлээгүй тул 4 зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.2-д заасан үндэслэлээр, тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан ч сунгуулах хүсэлтээ ирүүлээгүй тул 5 тусгай зөвшөөрлийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д заасан үндэслэлээр тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн.

III. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙЛГАХ ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байдлыг хангуулах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод, нээлттэй байлгахаар дараах байдлаар зохицуулсан. Тухайлбал:

- Өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгана. (Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.1);
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Зохицуулах хороонд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх мэдээллийг хүргүүлнэ. (Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.2);
- Тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх мэдээллийг Зохицуулах хороо олон нийтэд мэдээлнэ. (Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.5);
- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээллийг Зохицуулах хороонд гаргаж өгөөгүй, нуусан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авна. (Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19.6) гэж тус тус заасан байдаг.

ХХЗХ нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод мэдээлэх, хэт төвлөрөл бий болохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. (Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30.1.2)

ХХЗХ-оос хуульд заасан дээрх бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж, тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс эзэмшлийн мэдээллийг жил бүрийн

²¹ Лха хөх тэнгэр ХХК, Талст эрчим ХХК

²² Мөнхсаран чулуу ХХК

12 дугаар сарын 31-ний байдлаар хүлээн авч, нэгтгэн 1-р улиралд багтаан Хорооны цахим хуудсаар 2021 оноос жил бүр олон нийтэд ил тод мэдээлж байна. Энэхүү мэдээлэлтэй ХХЗХ-ны цахим хуудасны <https://shorturl.at/qAA8l> холбоосоор нэвтэрч танилцах боломжтой.

IV. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ, ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Нэг. Монгол Улсын хүн ам, өрхийн тоо, нягтралын байдал

Үндэсний Статистикийн хорооны 2025 оны статистикийн тайлангаар Монгол Улсын нийт хүн ам 3'591'120, өрхийн тоо 1'011'078 байгаагаас Улаанбаатар хотын хүн ам 1'796'045, өрхийн тоо 490'501, орон нутгийн хүн ам 1'795'075, өрхийн тоо 520'577 байна. Хүн амын тоо 2024 онтой харьцуулахад улсын хэмжээнд болон Улаанбаатар хот, орон нутгийн хэмжээнд адил 1%-иар өссөн байна. Энэ нь өмнөх 2023-2024 оны үзүүлэлттэй харьцуулахад Улаанбаатар хотын хүн амын өсөлтийн хувь буурсан бол орон нутгийн хүн амын өсөлтийн хувь нэмэгдсэн байна.

Хүн амын нягтралын түвшин 2025 онд Монгол Улсын хэмжээнд 2.3, баруун бүсийн хэмжээнд 1, хангайн бүс 1.6, төвийн бүс 1.1, зүүн бүс 0.8 байгаа нь өмнөх оныхтой ижил үзүүлэлттэй байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 382.1 болж нэмэгдсэн нь 2024 онтой харьцуулахад 4.6-ээр нэмэгдсэн үзүүлэлтийг үзүүлжээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг Үндэсний статистикийн хорооны <https://www.1212.mn/mn> сайтаас үзэх боломжтой.

Хоёр. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

ХХЗХ-ноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 230 байгаа нь 2025 оны мөн үетэй харьцуулахад 14-өөр буурсан байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд 20 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, шинээр 6 зөвшөөрөл олгосон байна.

Хүснэгт 6. Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээгээр

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл	Үйлчилгээ эрхлэгчийн тоо
Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ	1
Олон нийтийн телевиз, радио	Телевиз – 5 Радио - 4
Олон суваг дамжуулах үйлчилгээ	Улаанбаатар хот – 11 Орон нутагт - 14
Арилжааны телевизийн үйлчилгээ	Улаанбаатар хот –55 Орон нутагт – 3

Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ	Улаанбаатар хот –18 Орон нутагт – 36
Радиоогийн үйлчилгээ эрхлэгч	Улаанбаатар хот –29 Орон нутагт – 34
Төлбөртэй телевиз	20
НИЙТ	230

Гурав. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдал

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийг тусгай зөвшөөрлийн төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ тус бүрээр нь авч үздэг. Учир нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээ эрхлэх байршил, хүрээ ялгаатай байдгаас зах зээлийн хэмжээ, түүнээс олох орлого, үзэгч, сонсогч, хэрэглэгчийн тоо харилцан адилгүй байдаг. Иймээс зах зээлийн бүтэц, төвлөрөл, өрсөлдөөний түвшин нь үйлчилгээний төрөл, хамрах хүрээнээс ихээхэн хамаардаг учир үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх байр суурийг үнэлэхдээ эдгээр ялгаатай шинжийг харгалзан тус тусад нь шинжилгээ хийх шаардлагатай байдаг.

3.1. Телевизийн зах зээлийн хэмжээ, бүтэц

ХХЗХ-оос гаргасан 2025 оны статистикийн тайланд дурдсанаар Монголын телевизийн нийт зах зээл 2021-2024 оны хугацаанд тогтвортой өсөж, 2024 онд 120.4 тэрбум төгрөгт хүрсэн боловч 2025 онд 115.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 4.5 тэрбум төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна. Энэхүү бууралт нь өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн орлого өмнөх оноос 12.7 хувиар буурсантай шууд холбоотой байна.

Хүснэгт 7. Телевизийн зах зээлийн хэмжээ

Зах зээлийн хэмжээ (тэрбум төгрөгөөр)	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Өргөн нэвтрүүлгийн телевиз	44.6	55.3	61.4	81.0	70.7
Арилжааны телевиз	25.1	21.9	33.9	39.4	42.7
Төлбөртэй телевиз	-	-	-	-	2.5
Телевизийн нийт зах зээл	69.7	77.2	95.3	120.4	115.9

2025 оны байдлаар өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээл телевизийн нийт зах зээлийн 61 хувийг, арилжааны телевизийн зах зээл телевизийн нийт зах зээлийн 37 хувийг, төлбөртэй телевизийн зах зээл телевизийн нийт зах зээлийн 2.1 хувийг тус тус эзэлж байна.

Арилжааны телевизийн зах зээлийн хэмжээ өссөн хэдий ч өргөн нэвтрүүлгийн телевизийн орлого буурсан нь телевизийн нийт зах зээлийн хэмжээ буурахад голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 8. Телевизийн зах зээлийн хэмжээ - төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ тус бүрээр

Тусгай зөвшөөрлийн төрөл	Үйлчилгээ эрхлэх хүрээгээр	Зах зээлийн хэмжээ (тэрбум төгрөгөөр)	Зах зээлд эзлэх хэмжээ (хувиар)
Өргөн нэвтрүүлгийн телевиз	Улаанбаатар хотын	68.2	59%
	Орон нутгийн	2.4	2%
Арилжааны телевиз	Улаанбаатар хотын	42.6	37%
	Орон нутгийн	0.1	0.1%
Төлбөртэй телевиз	Төлбөртэй телевиз	2.5	2%
Нийт		115,9	100%

Телевизийн зах зээлийн орлогын дийлэнх хэсгийг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг телевизүүд бүрдүүлж байна. Тухайлбал 2025 оны статистикийн дүнгээр Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевиз нь телевизийн нийт зах зээлийн орлогын 59 хувийг, арилжааны телевиз нь 37 хувийг бүрдүүлж байна. Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевиз нь телевизийн зах зээлийн орлогын 2.1 хувийг бүрүүлж байгаа бол төлбөртэй телевиз 2 хувийг бүрдүүлж байна. Өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн орлогын 96.6 хувийг Улаанбаатар хотын, Монгол Улсад хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, үлдсэн 3.4 хувийг орон нутгийн 32 телевиз тус тус бүрдүүлж байна.

Харин өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевиз гэсэн тусгай зөвшөөрлийн төрлөөр нь зах зээлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна:

- Өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн орлогын 96.6 хувийг Улаанбаатар хотын 18 телевиз, бусад 3.4 хувийг орон нутгийн 36 телевиз бүрдүүлж байна.
- Арилжааны телевизийн зах зээлийн орлогын 99.8 хувийг Улаанбаатар хотын (МУ-д хамрах хүрээтэй 25) арилжааны 37 телевиз, үлдсэн хувийг орон нутгийн 3 арилжааны телевиз бүрдүүлж байна.

Хүснэгт 9. Өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн хэмжээ

Зах зээлийн хэмжээ	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн хэмжээ (тэрбум төг)	36,1	44,33	55,31	61,48	81,07	70,69

УБ хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн эзлэх хувь	93.9%	99,7%	99,6%	96,6%	96,7%	96,6%
Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизийн эзлэх хувь	6.1%	0.3%	0.4%	3.4%	3.3%	3.4%

Энэ нь телевизийн зах зээлийн орлого Улаанбаатар хотод өндөр төвлөрч байгааг харуулахын зэрэгцээ орон нутгийн телевизийн орлогын эх үүсвэр, санхүүгийн чадавх харьцангуй хязгаарлагдмал байгааг илтгэж байна. Орон нутгийн телевиз нийт үйлчилгээ эрхлэгчдийн тодорхой хувийг эзэлдэг боловч зах зээлийн орлогод оруулах хувь нэмэр бага байгаа нь тухайн орон нутгийн хүн ам, бизнесийн орчин, зар сурталчилгааны зах зээлийн хэмжээтэй шууд холбоотой юм. Түүнчлэн орон нутгийн телевиз нь тухайн аймаг, орон нутгийн иргэдэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг хүргэх үндсэн зорилготой, үйлчилгээ эрхлэх хүрээ нь хязгаарлагдмал байдаг. Иймд тэдгээрийн орлогын хэмжээ нь үйлчилгээний онцлог, хамрах хүрээ, тухайн бүс нутгийн зах зээлийн багтаамж, хүн амын төвлөрөл зэрэг бодит нөхцөлөөс ихээхэн хамаардаг.

Хүснэгт 10. Өргөн нэвтрүүлгийн телевизийн орлогын задаргаа

Өргөн нэвтрүүлгийн телевизийн орлогын задаргаа	Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн ТВ	Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн ТВ
Зар сурталчилгаа, үгэн зар	27.2%	8.3%
Ивээн тэтгэлт, бүтээгдэхүүн байршуулалт	25.9%	3.5%
ӨНТВ-ийн үйлчилгээний хөлс	20.9%	0%
Төлбөрт захиалгат нэвтрүүлэг	5.5%	18.5%
Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг, бизнес мэдээ	2.8%	11.2%
Өөрийн бүтээл борлуулалт	4.0%	2.2%
Бусад	13.7%	56.2%

Өргөн нэвтрүүлгийн телевизийн орлогыг бүрдүүлж буй задаргааг Хүснэгт 10-д Улаанбаатар хотын болон орон нутгийн телевизээр нь харьцуулан үзүүллээ. Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн орлогын дийлэнх хувийг зар сурталчилгаа, үгэн зарын орлого, нэвтрүүлгийн ивээн тэтгэлэг, бүтээгдэхүүн байршуулалтын орлого болон өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээний хөлсний орлого бүрдүүлж байгаа бол орон нутгийн телевизийн хувьд дийлэнх хувийг төлбөрт захиалгат нэвтрүүлэг болон “бусад” орлого бүрдүүлж байгаа нь зах зээлийн хувьд нилээдгүй ялгаатай нөхцөл байдалтай байгааг харуулж байна.

Тиймээс телевизийн салбарын өрсөлдөөн, төвлөрөл болон зах зээлийн нөхцөл байдлын үнэлгээнд Улаанбаатар хотын болон орон нутгийн телевизийн зах зээлийг нэг түвшинд авч үзэж, харьцуулах нь тохиромжгүй бөгөөд тус тусын онцлогийг харгалзан үнэлэх шаардлагатай юм. Иймээс телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл шинээр олгох, зах зээлд нэвтрэх нөхцөл болон төвлөрлийн үнэлгээ хийхдээ Улаанбаатар хотын болон орон нутгийн зах зээлийг ялгамжтай авч үзэх нь бодит нөхцөл байдалд нийцсэн зохицуулалтын шийдвэр гаргахад ач холбогдолтой юм.

Өргөн нэвтрүүлгийн телевизийн орлогын бүтцийг авч үзвэл Улаанбаатар хотын телевизийн орлогын бүтэц олон төрлийн орлогын эх үүсвэрт байхад орон нутгийн телевизийн орлого цөөн төрлийн эх үүсвэртэй байна.

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн орлогын хамгийн том эх үүсвэрийг зар сурталчилгаа, ивээн тэтгэлэг болон бүтээгдэхүүн байршуулалт бүрдүүлж байгаа бөгөөд эдгээр нь нийт орлогын 53.1 хувийг эзэлж байна. Мөн телевизийн үйлчилгээний хөлс нийт орлогын 20.9 хувийг бүрдүүлж байна.

Харин орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизийн орлогын бүтэц харьцангуй төвлөрсөн шинжтэй байна. Төлбөрт захиалгат нэвтрүүлэг, арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг, бизнес мэдээ зэрэг орлого нийт орлогын 29.7 хувийг эзэлж байгаа бол "бусад орлого" ангилал дангаараа 56.2 хувийг бүрдүүлж байна. Энэ нь орон нутгийн телевизийн орлогын ихээхэн хэсэг тогтмол бус, үндсэн үйл ажиллагаанаас гадуурх эх үүсвэрээс илүү бүрдэж байгааг харуулж байна.

Улаанбаатар хотын телевизийн орлогын 27.2 хувийг зар сурталчилгаа, 25.9 хувийг ивээн тэтгэлэг болон бүтээгдэхүүн байршуулалтын орлого бүрдүүлж байгаа нь эдгээр телевизүүд зах зээлд суурилсан орлогын эх үүсвэрээс санхүүжиж байгааг харуулж байна. Түүнчлэн телевизийн үйлчилгээний хөлс нийт орлогын 20.9 хувийг бүрдүүлж байгаа нь орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг дэмжихэд тодорхой хувь нэмэр оруулж байна.

Телевизийн үйл ажиллагааны эдийн засгийн хараат бус байдал нь зах зээлээс бүрдэх орлогын эх үүсвэрийн хэмжээ, бүтэцтэй нягт холбоотой байдаг. Энэ утгаараа Улаанбаатар хотын телевизийн орлого зар сурталчилгаа, ивээн тэтгэлэг, үйлчилгээний хөлс зэрэг хэд хэдэн үндсэн эх үүсвэрээс бүрдэж байгаа нь орлогын бүтцийн хувьд харьцангуй тогтвортой бөгөөд эдийн засгийн хувьд бие даан үйл ажиллагаа явуулах боломж өндөр байгааг харуулж байна. Харин орон нутгийн телевизийн зар сурталчилгааны орлогын эзлэх хувь бага байгаа нь тухайн бүс нутгийн зах зээлийн багтаамж, зар сурталчилгааны эрэлт, бизнесийн орчин харьцангуй хязгаарлагдмал байгааг илтгэж байна. Улмаар орон нутгийн телевизийн хувьд үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд үндсэн үйл ажиллагаанаас бусад орлогын эх үүсвэрээс илүү хамааралтай байх хандлагатай байгаа нь эдийн засгийн тогтвортой байдал болон урт хугацаанд хараат бус үйл ажиллагаа эрхлэх боломжид тодорхой сорилт үүсгэх эрсдэлтэй байгааг харуулж байна.

3.1.1. Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээл

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевиз статистик тайлан, мэдээллээ бүрэн ирүүлсэн. Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн хамгийн өндөр хувийг эзэлж байгаа эхний 4 телевиз Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн нийт зах зээлийн 56.1 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд 2 телевиз нь зах зээлийн 16-17 хувийг, үлдэх 2 телевиз нь 11.6 орчим хувьтай байна. Эдгээр телевизийн зах зээлд эзлэх байр суурь нь 2024 онтой харьцуулахад өөрчлөгдөөгүй байна. Харин 5, 6 дугаар байрт эрэмбэлэгдсэн телевиз тус бүр зах зээлийн 6 орчим хувийг эзэлж байгаа бол үлдсэн 12 телевизийн зах зээлд эзлэх хувь тус бүр 4 болон түүнээс доош хувьтай, эдгээр 14 телевиз нь нийлээд Улаанбаатар хотын зах зээлийн 43 хувийг бүрдүүлжээ.

Энэ нь Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлд цөөн тооны томоохон телевиз орлогын талаас илүү хэсгийг бүрдүүлж байгаа хэдий ч бусад телевизүүд тодорхой хэмжээнд зах зээлд оролцож, өрсөлдөөний орчин хадгалагдаж байгааг харуулж байна.

Хүснэгт 11. Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн орлого, зардлын хэмжээ

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээл	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Орлого (тэрбум төг)	33,8	42,5	53,7	59,38	78,32	68,24
Зардал (тэрбум төг)	30,9	40,1	43,9	53,57	64,85	58,27

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн орлого 2020-2024 оны хугацаанд тогтвортой өсөж, 2024 онд 78.3 тэрбум төгрөгт хүрсэн боловч 2025 онд 68.2 тэрбум төгрөг болж өмнөх оноос 10.1 тэрбум төгрөгөөр буюу 12.9 хувиар буурсан байна. Нийт зардал 64.9 тэрбум төгрөгөөс 58.3 тэрбум төгрөг болж 10.1 хувиар буурсан хэдий ч орлогын бууралтын түвшин зардлын бууралтаас илүү өндөр байгаа нь зах зээлийн өсөлт саарч, орлогын эх үүсвэрүүдэд дарамт үүсэж байгааг харуулж байна.

Нөгөө талаар, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн нийт зардал 2020-2024 онд хоёр дахин өссөн нь контент үйлдвэрлэл, хүний нөөц, техник технологийн шинэчлэл зэрэг үйл ажиллагааны зардал тогтмол нэмэгдсэнийг илэрхийлж байгаа бөгөөд 2025 оны бууралт нь үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, зардлаа танах арга хэмжээ авсантай холбоотой байх боломжтой байна.

Нөгөө талаар Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн зардал 2020 оноос хойш тогтмол өсөж байсан бол 2025 онд буурсан байна. Үүнд:

2020 онд - 30,9 тэрбум төгрөг, 2021 онд - 40,1 тэрбум төгрөг, 2022 онд - 43,9 тэрбум төгрөг, 2023 онд - 54,6 тэрбум төгрөг, 2024 онд - 64,8 тэрбум төгрөг, 2025 онд – 58.2 тэрбум төгрөг байна.

2025 онд өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчид салбарт нийт 9,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс 8,4 тэрбум төгрөг буюу 92 хувийг Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевиз бүрдүүлж байгаа нь зах зээлийн орлого буурсан нөхцөлд ч техник, технологийн шинэчлэл, контент үйлдвэрлэл болон үйл ажиллагааны хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт үргэлжилж байгааг харуулж байна. Түүнчлэн орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевиз нийтдээ 721 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь зах зээлийн хэмжээ, орлогын боломж харьцангуй хязгаарлагдмал нөхцөлд ч тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгааг илтгэж байна.

Хүснэгт 12. Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний түвшин

Төвлөрөл, өрсөлдөөний үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Төвлөрлийн хувь (CR)	64%	56%	43%	59%	62%	56%
Херфиндал - Хиршман Индекс (НИИ)	1116	1093	949	815	1031	814

Зах зээл дэх төвлөрлийн түвшин (Concentration ratio²³, төвлөрлийн түвшин цаашид (CR гэх) болон өрсөлдөөний индекст (Herfindahl–Hirschman index²⁴ өрсөлдөөний түвшин, цаашид НИИ гэх) тулгуурласан 2020–2025 оны үзүүлэлтээс харахад Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний үзүүлэлтүүдийг авч үзвэл зах зээл дунд түвшний төвлөрөлтэй, харьцангуй өрсөлдөөнт бүтэцтэй байна. Хэдийгээр зах зээлд тэргүүлэгч цөөн телевиз нийт орлогын томоохон хэсгийг бүрдүүлж байгаа боловч НИИ үзүүлэлт бүх хугацаанд 1,500-аас доош буюу төвлөрөл багатай зах зээлийн түвшинд хадгалагдсан нь зах зээлд хангалттай тооны үйлчилгээ эрхлэгч өрсөлдөж байгааг харуулж байна. Тухайлбал:

2020 онд CR 64%, НИИ 1116-тай байснаар зах зээл дунд зэрэг төвлөрсөн, өрсөлдөөн дунд түвшинд байгааг харуулж байсан бол 2023 онд CR 59%, НИИ-815 болж буурсан нь зах зээлийн бүтэц илүү тэнцвэртэй болж, үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь ойролцоо, зарим телевизийн давамгайл байдал суларсныг илтгэж байна. Энэ нь зах зээлд төвлөрөл буурч, өрсөлдөөний түвшин нэмэгдсэн үзүүлэлт юм. Харин 2024 онд CR 62%, НИИ 1031 болж өссөн нь зах зээлийн төвлөрлийн түвшин дахин нэмэгдэж, өрсөлдөөн дунд түвшинд хадгалагдаж буйг харуулж байна. Тэгвэл 2025 онд CR 56%, НИИ-814 болж буурсан байна. Эдгээр үзүүлэлт нь зах

²³ Төвлөрлийн харьцааны индекс нь 1-ээс 100 хувийн утга авах бөгөөд үүгээр тухайн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний нөхцөл байдлыг тодорхойлно. Өрсөлдөөний зохицуулалтын практикт ихэнхдээ зах зээл дэх 3, 4, эсвэл 5 томоохон үйлчилгээ эрхлэгчийн төвлөрлийг тодорхойлж үздэг ба хэрэв индексийн утга 80-100 бол төвлөрлийн түвшин өндөр, 50-80 бол төвлөрлийн түвшин дундаж, 0-50 бол төвлөрлийн түвшин бага гэж үзнэ.

²⁴ Энэхүү индекс нэгтэй тэнцүү байх нөхцөлд тухайн зах зээлд зөвхөн нэг үйлчилгээ эрхлэгч (монопол) байна. Хэрэв индексийн утга ХХИ<ХХИ1800 бол тухайн зах зээлд төвлөрлийн түвшин өндөр буюу өрсөлдөөн хязгаарлагдмал гэж үзнэ.

зээлд хангалттай тооны тоглогчтой өрсөлдөөний орчин хадгалагдаж байгааг илтгэх боловч томоохон телевизийн зах зээлд эзлэх нөлөө хэвээр байсаар байгааг илэрхийлж байна.

Нөгөө талаас Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээл нь өрсөлдөөний хувьд төвлөрөл багатай, олон тоглогчтой бүтэцтэй бөгөөд төвлөрлийн үзүүлэлтүүдээс харахад зах зээлд давамгайл байдал үүсээгүй, өрсөлдөөний орчин хадгалагдаж байна. Гэсэн хэдий ч 2025 онд зах зээлийн нийт орлого буурсан нь зах зээлийн бодит багтаамж, цаашдын өсөлтийн боломжид анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Телевизийн нийт зах зээлийн бүтцийг авч үзвэл өргөн нэвтрүүлгийн телевиз нийт зах зээлийн 61.0 хувийг, арилжааны телевиз 36.9 хувийг тус тус эзэлж байна. Хэдийгээр эдгээр үйлчилгээ нь тусгай зөвшөөрлийн төрөл, хуулиар хүлээх үүрэг, эдлэх эрхийн хувьд ялгаатай боловч Улаанбаатар хотын телевизийн зах зээлийн хүрээнд үзэгчдийн анхаарал, зар сурталчилгааны орлого болон контентын зах зээлд зэрэгцэн үйл ажиллагаа явуулж, өрсөлдөж байна.

Иймээс үйлчилгээний эрх зүйн ангилал өөр боловч эдийн засгийн агуулгын хувьд өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевиз нь нэг зах зээлд өрсөлдөж байгаа оролцогчид гэж үзэж болно. Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн телевиз зах зээлийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлж байгаа нь телевизийн салбарын үндсэн өрсөлдөөн, хөрөнгө оруулалт болон үзэгчдийн хүртээмжийн төвлөрөл энэ сегментэд илүү төвлөрч, хадгалагдсаар байгааг харуулж байна.

Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн телевиз нь үндсэн багцын эхэнд заавал байрлах, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс авах, төрийн өмчийн радио, телевизийн сүлжээгээр үнэ төлбөргүй дамжуулах, зэрэг хуулиар олгогдсон давуу нөхцөлтэй байдаг. Иймд телевизийн зах зээлд тэгш өрсөлдөөнийг хангах суурь нөхцөл бүрдээгүй, өрсөлдөөний орчныг сайжруулах бодлогын шинэчлэл хийгдээгүй нөхцөлд өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэх нь зөвхөн тухайн ангиллын телевизийн өрсөлдөөнд бус, телевизийн нийт зах зээлийн өрсөлдөөний тэнцвэрт байдалд нөлөөлөх боломжтой гэж үзэж байна.

Эдийн засгийн агуулгын хувьд нэг зах зээлд өрсөлдөж байгаа боловч эрх зүйн хувьд өөр ангиллын тусгай зөвшөөрлөөр зохицуулагдаж байгаа өнөөгийн тогтолцооны үр нөлөө, өрсөлдөөний орчинд үзүүлэх нөлөөллийг цаашид хууль, эрх зүйн хүрээнд дахин үнэлж, хууль эрхзүй, зохицуулалтын шинэчлэлийн хүрээнд нэг талаас зах зээлийн өрсөлдөөний тэгш орчныг хангах, нөгөө талаас үндэсний болон олон нийтийн нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилгоор зайлшгүй бэлтгэн нэвтрүүлэх үүргийг хэрэгжүүлэх, олон ургальч үзлийг дэмжих онцлог чиг зохицуулалтыг хадгалах замаар хууль эрхзүй зохицуулалтын оновчтой хэлбэрийг судлан боловсронгуй болгох шаардлагатай байна.

Иймээс өрсөлдөөний орчныг үнэлэхдээ зөвхөн өргөн нэвтрүүлгийн телевизийн хүрээнд дээрх зах зээлийн мэдээлэлд хийсэн үнэлгээнд тулгуурлах бус, Улаанбаатар хотын телевизийн нийт зах зээлийн түвшинд өрсөлдөөний орчныг бүх талаас нь авч үзэх шаардлагатай. Үүнд өргөн нэвтрүүлгийн телевизэд хуулиар олгогдсон эрх, давуу нөхцөл нь зах зээл дэх өрсөлдөөний тэгш байдалд хэрхэн нөлөөлж байгаа эсэх, зөвшөөрлийн тоог нэмэгдүүлснээр хэрэглэгчийн сонголт, үйлчилгээний чанар, олон ургальч байдлыг нэмэгдүүлэх боломж болон үүнээс үүдэж болзошгүй сөрөг үр дагавар, түүнчлэн зах зээлийн бодит хэрэгцээ, зар

сурталчилгааны зах зээлийн багтаамж зэргийг хамтад нь үнэлж авч үзэх нь зүйтэй. Ийнхүү зах зээлийн нөхцөл байдал, хэрэглэгч болон олон нийтийн эрх ашиг, хууль эрхзүй, зохицуулалтын орчныг цогцоор нь харгалзан үзсэн тохиолдолд өрсөлдөөний орчны талаарх үнэлэлт, дүгнэлт илүү бодитой, үндэслэлтэй байх боломжтой юм.

Харин цаашид дээр дурдсанчлан зах зээлийн хэмжээ, орлогын өсөлт, хөрөнгө оруулалтын түвшин, өрсөлдөөний нөхцөл байдал, түүнчлэн бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын орчинд гарч буй өөрчлөлтийг тогтмол үнэлж, бодит шаардлага үүссэн тохиолдолд тухайн зах зээлд шинэ тоглогч нэвтрүүлэх асуудлыг дахин авч үзэх боломжтой юм. Ингэхдээ зөвхөн зах зээлийн үзүүлэлтүүдэд тулгуурлах бус, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний нийтийн ашиг сонирхолд чиглэсэн онцлог чиг үүрэг, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, үйлчилгээний хүртээмж, олон ургальч байдлыг хангах шаардлага болон зах зээлийн хөгжлийн төлвийг хамтатган үнэлэх нь зүйтэй гэж үзэж байна.

3.1.2. Улаанбаатар хотын арилжааны телевизийн зах зээл

Статистик тайлан ирүүлсэн арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2020-2025 оны хооронд хэлбэлзэлтэй байсан ч (2020 онд 28, 2021 онд 36, 2022 онд 29, 2023 онд 43, 2024 онд 40, 2025 онд 42) сүүлийн жилүүдэд тогтмол өсч байгааг харуулж байна. Энэ нь телевизийн салбарын зах зээлийн статистик мэдээллийг илүү үнэн зөв, бүрэн гүйцэт цуглуулах, дүн шинжилгээ хийх суурь нөхцлийг бүрдүүлж байна. Нийт Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулах арилжааны телевизийн 50 тусгай зөвшөөрөл олгогдсон байгаагаас 6 телевиз үйл ажиллагаа явуулж эхлээгүй, 2 телевиз үйл ажиллагаагаа түр зогсоосон, 5 телевиз үйл ажиллагаа явуулж байгаа ч х тайлан ирүүлсэн, 2 телевиз өргөн нэвтрүүлгийн телевизтэй нэг эзэмшилтэй тул өргөн нэвтрүүлгийн телевизтэй хамт ирүүлсэн гэсэн тайлбартай байна.

Арилжааны телевизийн зах зээлд топ 4 телевизийн эзлэх хувь 2022 онд 76% байсан бол 2023 онд 87%-д хүрч өссөн ч 2024 онд 84% болж өмнөх оноос бага зэрэг буурсан бол 2025 онд 84.5% болж бага зэрэг өссөн байна.

Хүснэгт 13. Арилжааны телевизийн орлогын задаргаа

Арилжааны телевизийн орлогын задаргаа	2025 он
Өөрийн бүтээл борлуулалт	43.4%
Зар сурталчилгаа, үгэн зар	37.5%
Ивээн тэтгэлт, бүтээгдэхүүн байршуулалт	2.8%
Төлбөрт захиалгат нэвтрүүлэг	4.8%
Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг, бизнес мэдээ	0.4%
Бусад	11.1%

2020–2025 оны хооронд Улаанбаатар хотын арилжааны телевизийн зах зээлд төвлөрлийн түвшин ерөнхийдөө өндөр байсан бөгөөд CR үзүүлэлт 76–87 хувь, ННН 1498–3000-ийн хооронд хэлбэлзэж, 2021 оныг эс тооцвол бусад жилүүдэд зах зээл "өндөр төвлөрсөн, өрсөлдөөн хязгаарлагдмал" ангилалд багтаж байлаа. Тухайлбал 2020 онд CR 84%, ННН 1864-тай байсан бол 2021 оноос хойш ННН үзүүлэлт өссөн, зах зээлийн төвлөрөл нэмэгдэж, өрсөлдөөн улам бүр хязгаарлагдмал болсон нь цөөн тооны тоглогчид зах зээлийн голлох орлогыг бүрдүүлж байгааг илтгэнэ.

Хүснэгт 14. Улаанбаатар хотын арилжааны телевизийн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний түвшин

Төвлөрөл, өрсөлдөөний үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Төвлөрлийн хувь (CR)	84.1%	76%	83.3%	87%	84%	84.5%
Херфиндал-Хиршман Индекс (ННН)	1864	1498	1929	2999	2758	3000

Арилжааны телевизийн зардлын хэмжээ 2020-2025 онд хэлбэлзэж байсан ч ерөнхийдөө өсөх хандлагатай байна. Тухайлбал: зардал 2020 онд 23.9 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 19,5 тэрбум төгрөг болж саарсан хэдий ч 2023, 2024 онд эрс нэмэгдэж, 2023 онд 38 тэрбум төгрөг, 2024 онд 42,6 тэрбум төгрөг болж өссөн бол 2025 онд 40,8 болж бага зэрэг буурчээ. Харин арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 2022 онд 4,6 тэрбум төгрөг байсан бол 2023 онд буурч 1 тэрбум төгрөгт болсон ч 2024 онд дахин өсч 6,2 тэрбум төгрөгт хүрсэн бол 2025 онд 2,5 тэрбум төгрөг болж буурсан байна. Статистикийн мэдээллийн дэлгэрэнгүйгээс харахад цөөн тооны телевиз хөрөнгө оруулалт хийсэн байдалтай байна.

Нөгөө талаар арилжааны телевизийн хувьд орлогоо тайлагнаагүй, эсхүл “Орлого байхгүй” буюу Х тайлан ирүүлсэн, зах зээлд 10 гаруй жил үйл ажиллагаа явуулж байгаа ч зардлаа нөхөж чадахгүй, санхүүгийн хувьд тогтвортой бус 10 орчим телевиз зах зээлд оршин тогтносон хэвээр байна.

Дээрх зах зээлийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд арилжааны телевизийн хувьд зах зээлийн төвлөрлийн түвшин харьцангуй өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал байгааг харуулж байна. Олон тооны телевиз үйл ажиллагаа эрхлэж байгаа хэдий ч зах зээлийн ихэнх хувийг цөөн тооны телевиз эзэлж, үлдсэн олон тооны телевизийн оролцоо сул, зах зээлд үзүүлэх нөлөө бага байгаа нь бодит өрсөлдөөн хангалтгүй байгааг илтгэж байна. Зах зээлийн бүтэц, өрсөлдөөний нөхцөл нь зөвхөн телевизийн тоогоор бус, үйлчилгээ эрхлэгчдийн чадавхи, технологийн дэвшил, контентын чанар зэрэг хүчин зүйлээс ихээхэн хамаарч байна. Өнөөдөр өндөр чадавхитай, мэргэжлийн баг хамт олонтой, дэвшилтэт технологи ашиглан, үзэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай контент үйлдвэрлэж чадах телевизүүд зах зээлд өрсөлдөх чадвартай байна. Иймд зах зээлийн бүтэц, өрсөлдөөний нөхцлийг сайжруулахын тулд зөвхөн телевизийн тоон үзүүлэлтэд үндэслэх бус, үйлчилгээ

эрхлэгчдийн үйл ажиллагааны чадавхи, тогтвортой үйл ажиллагаа эрхлэх боломж, зах зээлд шинэчлэл авчрах нөөц бололцоог харгалзан үзэх шаардлага тулгарч байна.

Иймээс зах зээлд чадавхитай, мэргэжлийн үйлчилгээ эрхлэгчдийг шинээр нэвтрэх боломжийг хангахын тулд зохицуулалтын хязгаарлалтыг аль болох оновчтой болгож, хэт хүндрэл учруулахгүй байх нь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, хөтөлбөрийн олон талт байдал, контентийн чанарыг сайжруулах чухал нөхцөл болно гэж үзэж байна.

3.2. Олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээл

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 25 үйлчилгээ эрхлэгчээс 24 үйлчилгээ эрхлэгч (96%) тайлан мэдээ ирүүлсний 1 нь х тайлан ирүүлсэн байна. Харин Улаанбаатар хотын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид бүгд статистик тайлан, мэдээ ирүүлсэн байна.

Хүснэгт 15. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тооны өөрчлөлт
(идэвхтэй хэрэглэгчийн тоо²⁵гоор)


Олон сувгийн хэрэглэгчийн тоо	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Нийт идэвхтэй хэрэглэгч	808,463	760,028	761,800	753,790	769,440²⁶
Үүнээс Улаанбаатар хот	456,691	424,925	447,738	448,000	476,136
Үүнээс Орон нутаг	351,772	335,103	314,062	305,800	293,304

Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо 2025 оны жилийн эцсийн байдлаар 769,440 байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 2.08% өссөн үзүүлэлт үзүүлж байна. Хэрэглэгчийн тоог өрхийн тоотой харьцуулахад нийт өрхийн 75.2% нь олон суваг дамжуулах үйлчилгээ авч байна гэж үзэж болохоор байна. Олон суваг дамжуулах үйлчилгээг интернэтээр буюу ОТТ технологиор авч байгаа хэрэглэгчийн тоо 220,150 байгаа нь 44.31%-ийн өсөлтийг үзүүлжээ. Улаанбаатар хотын хэрэглэгчийн тоо сүүлийн 4 жил өссөн үзүүлэлттэй байгаа бол эсрэгээрээ орон нутгийн хэрэглэгчийн тоо тогтмол буурсан үзүүлэлттэй байна.

²⁵ Сүүлийн 3 сарын хугацаанд төлбөрт төлж үйлчилгээ авсан хэрэглэгчийн тоог идэвхтэй хэрэглэгч гэж авч үздэг

²⁶ ОТТ үйлчилгээний болон радио, телевизийг газрын сүлжээгээр олон суваг дамжуулах үйлчилгээ авч байгаа хэрэглэгчийн тоо ороогүй болно.


Зураг 1. Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр



Үүнийг олон сувгийн үйлчилгээний технологийн ялгаатай байдлаар нь авч үзье. АйПиТВ-үүд гэр хороололд болон олон нутагт үйлчилгээ үзүүлэх болсонтой холбоотойгоор тухайн орон нутгийн болон Улаанбаатар хотын гэр хороололд үйлчилгээ үзүүлж байсан олон сувгийн үйлчилгээ эрхлэгчид үйл ажиллагаагаа зогсооход хүрч байна гэж дүгнэж болохоор байгаа юм. Үүнийгээ дагаад кабелиар телевизийн олон суваг хүлээн авч байгаа хэрэглэгчийн тоо эрчимтэй багасаж байна. Үүнд мөн интернэтээр буюу ОТТ үйлчилгээний хэрэглэгчийн тоо нэмэгдэж байгаа нь тодорхой хэмжээгээр нөлөөлж байна гэж дүгнэж болохоор байна.

Улаанбаатар хот болон орон нутгийн хэрэглэгчийг олон суваг дамжуулах үйлчилгээ авч байгаа технологийн төрлөөр нь авч үзэхэд дараах зурагт харуулсан нөхцөл байдалтай харагдаж байна.

Зураг 2. Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр, хувиар



Улаанбаатар хотын хэрэглэгчдийн 80.1% нь АйПиТВ-ээр телевизийн олон суваг хүлээн авч үзэж байгаа бол орон нутгийн хэрэглэгчдийн 52.4% нь хиймэл дагуулаар телевизийн олон суваг хүлээн авч үзэж байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлийн хэмжээ 2022 онд 181,38 тэрбум төгрөг, 2023 онд 212,77 тэрбум төгрөг, 2024 онд 259,28 тэрбум төгрөгт хүрч, 2025 онд 309,16 тэрбум төгрөг болж зах зээлийн хэмжээ тасралтгүй өссөн байна. 2025 онд олон суваг дамжуулах үйлчилгээний нийт орлого өмнөх оноос ердөө 19.3%-иар өссөн нь энэ онд ОТТ үйлчилгээний орлогыг оруулж тооцсонтой холбоотой байна. Өнгөрсөн онуудад АйПиТВ үйлчилгээний орлогын өсөлтийн хувь өндөр байсан бол энэ онд ердөө 0.3% өсөлт үзүүлжээ. Хэрэглэгчийн тооны бууралттай холбоотойгоор хиймэл дагуулын үйлчилгээний орлого 2025 онд өмнөх оноос 1.3%-аар буурсан байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлд дижитал шилжилт эрчимтэй өрнөж, хэрэглэгчдийн хэрэглээ уламжлалт технологиос интернэтэд суурилсан, ухаалаг төхөөрөмжөөр хүссэн үедээ хандах боломжтой үйлчилгээнд шилжиж буйг зах зээлийн хандлага харуулж байна. Тухайлбал уламжлалт ОСДҮЭ-ийн хэрэглэгчийн тоо буурах хандлагатай байгаа бол интернет протоколд суурилсан АйПиТВ хэрэглэгчийн тоо тогтмол өсч, үүний зэрэгцээ ОТТ үйлчилгээний хэрэглээ ч мөн эрчимтэй нэмэгдэж байна. Эдгээр үзүүлэлтүүд нь олон нийт контентоо улам бүр дижитал, ухаалаг, хэрэглэгч төвтэй хэлбэрээр хүлээн авах сонирхолтой болж байгааг илтгэж байна.

2025 онд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн нийт зардал 181.64 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үүний зэрэгцээ хөрөнгө оруулалтын хэмжээ 2022-2024 онуудад тасралтгүй буурч байсан бол 2025 онд 18,16 тэрбум болсон нь 2024 онтой харьцуулахад 33%-иар өссөн байна.

Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын хэмжээ нэмэгдэж байгаа бөгөөд 2025 онд 56.3 тэрбум төгрөг байгаа нь 2024 онтой харьцуулахад 12%-иар өссөн байна.

Нэгж хэрэглэгчээс олох сарын дундаж орлого тогтмол өсөх хандлагатай байгаа бөгөөд 2022 онд 17,530 төгрөг байсан бол 2023 онд 19,767 төгрөг, 2024 онд 23,982 төгрөг, 2025 онд 33,875 төгрөг болж нэмэгдсэн байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлд төвлөрлийн түвшин сүүлийн дөрвөн жилийн хугацаанд тогтмол өсөж, зах зээлийн өрсөлдөөн улам бүр хумигдсан байна. Үүнийг дараах үзүүлэлтүүд илтгэж байна.

Хүснэгт 16. Улаанбаатар хотын олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний түвшин

Төвлөрөл, өрсөлдөөний үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Төвлөрлийн хувь (CR)	86%	94%	94.2%	96.6%	93%
Херфиндал-Хиршман Индекс (HHI)	2700	3644	4292	5000	3104

Зах зээл дэх төвлөрлийн хувь 2021 онд CR 86% байсан бол 2024 онд 96.6%-д хүрч 2025 онд 93% болж бага зэрэг буурсан ч зах зээл голлох хэсэг цөөн хэдэн үйлчилгээ эрхлэгчид төвлөрсөн байгаа хэвээр байна.

Харин өрсөлдөөний түвшинг илэрхийлдэг ННІ индекс 2021 онд 2700 байсан бол 2024 онд ННІ 5000-д хүрч нь зах зээл өндөр төвлөрөлтэй, өрсөлдөөн хязгаарлагдмал түвшинд очсоныг илтгэж байгаа бөгөөд 2025 онд 3104 болж буурсан ч өрсөлдөөн хязгаарлагдмал хэвээр байна.

3.3. Радиогийн зах зээлийн хэмжээ:

Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 55 зөвшөөрөл эзэмшигч байгаагаас үйл ажиллагаа түр зогсоосон 12, үйл ажиллагаа эхлээгүй 2 радио байна. Харин телевиз, радиогийн үйлчилгээ давхар эрхэлдэг бол ихэвчлэн телевиз дээрээ санхүүгийн мэдээллээ ирүүлсэн байна.

Сүүлийн таван жилийн байдлаар радиогийн зах зээл тогтвортой өсөлттэй байна. Зах зээлийн нийт хэмжээ 2020 онд 1.5 тэрбум төгрөг байсан бол үүнээс хойш тогтвортой өссөөр 2021 онд 2.2 тэрбум төгрөг, 2022 онд 3.3 тэрбум төгрөг, 2023 онд 3.3 тэрбум төгрөг, 2024 онд 5 тэрбум төгрөгт хүрч, 2025 оны статистикийн тайлан, мэдээгээр 5.5 тэрбум төгрөг болж сүүлийн 6 жилийн хугацаанд 3.6 дахин өссөн байна. Гэвч нийт орлогын 90 дээш хувийг Улаанбаатар хотын радионууд бүрдүүлж байгаа бөгөөд 2025 онд 98.6%-д хүрсэн байна.

Зардлын хувьд 2020–2022 онд тогтвортой түвшинд хадгалагдаж байсан бол 2023–2024 онд огцом өссөн бөгөөд 2024 онд нийт зардал 3.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 43%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байсан бол 2025 онд 2.3 тэрбум төгрөг болж бууран 2023 оны үзүүлэлттэй адил болсон байна.

Хүснэгт 17. Улаанбаатар хотын радиогийн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний түвшин

Төвлөрөл, өрсөлдөөний үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Төвлөрлийн хувь (CR)	90%	91%	93%	90.1%	92%
Херфиндал-Хиршман Индекс (ННІ)	4719	4674	6039	6542	6674

Сүүлийн таван жилийн хугацаанд Улаанбаатар хотын радиогийн зах зээлд төвлөрлийн түвшин өндөр байдал тогтвортой байгаа нь өрсөлдөөний орчин хязгаарлагдмал, цөөн тооны үйлчилгээ эрхлэгч зах зээлийг давамгайлж байгааг харуулж байна.

CR үзүүлэлт 90%-иас дээш түвшинд тогтвортой хадгалагдаж байгаа бөгөөд ННІ үзүүлэлт 2021-2022 онд гэхэд л төвлөрлийн өндөр түвшинд хүрснийг илэрхийлж байсан бол 2023 оноос эхлэн 6000-аас дээш өсөж, зах зээлд маш өндөр төвлөрөл үүссэн, өрсөлдөөн ч маш хязгаарлагдмал болсныг харуулж байна.

Радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн салбарт оруулсан нийт хөрөнгө оруулалт 450,2 сая төгрөг байна.

Дөрөв. Эрэлт, хэрэгцээ

ХХЗХ нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасны дагуу 2021 оноос өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог жил бүр тогтоож байгаа бөгөөд тухайн үйлчилгээг эрхлэх эрэлт, хэрэгцээ байгаа эсийг тодорхойлох зорилгоор судалгааны асуулга буюу мэдээлэл ирүүлэх маягт гаргаж өөрийн цахим хуудаст <https://shorturl.at/ptMbs> байршуулж сонирхогч эдгээдүүдээс мэдээлэл хүлээн авч ажиллаж байна.

Энэ дагуу дээр дурдсан судалгаа, сонирхогч этгээдүүдээ ирүүлсэн хүсэлт, мэдээлэл, зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, өрсөлдөөний нөхцөл байдалд үндэслэн 2021 оноос хойш жил бүрийн 2 дугаар улиралд тухайн жилд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоог тусгай зөвшөөрлийн төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ, байршил тус бүрээр гаргасан.

Сонгон шалгаруулалтаар 2021-2025 онуудад нийт олон суваг дамжуулах үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох тоог 3 гэж тогтоосноос сонгон шалгаруулалтаар 2 тусгай зөвшөөрөл олгосон, өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөл олгох тоог нийт 19 гэж тогтоож сонгон шалгаруулалт зарласнаас 9 тусгай зөвшөөрөл, арилжааны телевизийн тусгай зөвшөөрөл олгох тоог нийт 7 гэж тогтоосноор 6 тусгай зөвшөөрөл, арилжааны радиогийн тусгай зөвшөөрөл олгох тоог нийт 40 гэж тогтоосноос сонгон шалгаруулалтаар 19 тусгай зөвшөөрөл тус тус олгогдоод байна.

Дэлгэрэнгүйг тусгай зөвшөөрлийн төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ тус бүрээр доорх хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 18. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн тоо тогтоосон, олгосон байдал

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл	Квот тогтоосон, сонгон шалгаруулалтаар олгосон байдал			
	Монгол Улсын нутаг дэвсгэрт	Улаанбаатар хотод	Аймагт	Нийт зарласан/ олгосон
Олон суваг дамжуулах	2021 онд 1/1 2023 онд 1/0 2025 онд 1/0	-	2023 онд 1/1	4/2
Өргөн нэвтрүүлгийн телевиз	-	-	2021 онд 8 аймагт 11/6 (6 аймагт) 2023 онд 7/2 2025 онд 1/1	19/9
Арилжааны телевиз	2024 онд 1/1 2025 онд 3/3	2025 онд 2/2	2023 онд 1/0 2025 онд 2/0	9/6

Арилжааны радио	-	-	2021 онд 12 аймагт 12/2 (т.з гэрээ байгуулаагүй тул хүчингүй болгосон) 2022 онд 3/2 2023 онд 10/6 2024 онд 10 аймагт 11/11 (10 аймагт-4 үйлчилгээ эрхлэгч) 2025 онд 4/0	40/19
-----------------	---	---	---	-------

2026 онд Улаанбаатар хотод олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх 1 хүсэлт, Улаанбаатар хотод арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх 1 хүсэлт, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд өргөн нэвтрүүлгийн телевиз болон арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тус бүр 1 хүсэлт ирсэн.

V. ХОРООНООС 2026 ОНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОО ТОГТООХ ЭСЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ХАРГАЛЗАН ҮЗСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ШИЙДВЭР

Нэг. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлтүүд

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрлийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйл, тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9 дэх заалтаар тус тус тогтоосон.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлнэ.” гэж; 7 дугаар зүйлийн 7.4.2-т “өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэх;” гэж; 7.4.5-д “энэ хуулийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах;” гэж; 30 дугаар зүйлийн 30.1.9-д “өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоох;” гэж; 30.1.10-т “хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;” гэж тус тус тодорхойлсны дагуу ХХЗХ-ноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой харилцааг хуульчилсан.

Зөвшөөрлийн тухай хууль батлагдаж 2023 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох журмыг тусгаж, үүнтэй холбоотой ХХЗХ-ны 2020 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн

журам”-ыг тус хорооны 2023 оны 2 тоот тогтоолоор хүчингүй болгосон. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9-д заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгоно.” гэж заасны дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх дараах төрлийн тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулах зарчмыг баримтлан олгодог. Үүнд:

- Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх;
- Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх;
- Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх;
- Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх;

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн дээрх төрөлд нээлттэй сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох тоо тогтооход Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9-ийн дагуу өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэхээр заасан бөгөөд судалгааг дараах холбогдох чиглэлд хийж, уг судалгаанд үндэслэн сонгон шалгаруулалт зарлах шаардлагатай эсэхэд дүгнэлт гаргасан болно.

1. Монгол Улс, Улаанбаатар хот, орон нутгийн хүн ам, өрхийн тоо, нягтралын судалгаа;
2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо;
3. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгаа;
4. Эрэлт, хэрэгцээ;

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд холбогдох дээрх судалгаа, мэдээллээс гадна дараах шалгуурыг харгалзан үзсэн. Үүнд:

1. Радио давтамжийн тусгай зөвшөөрөл шаардлагатай бол радио давтамжийн төлөвлөлт, нөөц;
2. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасан зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээний сувгийн багтаамж, нөхцөл байдал;

Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээний ашиглалтыг төр хариуцах бөгөөд уг сүлжээнд олон нийтийн радио, телевиз болон өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг үнэ төлбөргүйгээр холбох, дамжуулах хуулийн зохицуулалт хэрэгждэг ба нээлттэй сонгон шалгаруулалтаар өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тоо тогтоох нөхцөлд газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн сүлжээ, сувгийн багтаамж, техникийн нөхцөл байдлыг харгалзан авч үзэх шаардлагатай байдаг. Иймээс Радио, телевизийн газрын сүлжээ УТҮГ-аас техникийн нөхцөлийг авч үзсэн.

Хоёр: Тус Хорооноос 2026 онд сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох тухай

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газраас Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалтыг үндэслэн Өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаар хийсэн судалгаа, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх талаар судалгаа, дүгнэлтийг хийж 2026 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Хорооны хуралдаанд тус тус танилцуулж, Хорооны 76 тоот тогтоолоор 2026 онд олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоосон. Хорооны тогтоолтой <https://www.crc.gov.mn/documents/xxzx-togtool> холбоосоор орж танилцах боломжтой.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО